

БАТЛАВ
 МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
 Я.СОДБААТАР
 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

2021 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ, ӨДӨРЛӨГИЙН ХУВААРЬ

А/А	Нэгдсэн арга хэмжээний нэр		2021 он											
			1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	"Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагааг, ам эхгүйн нэгж, байгууллага айл өрхийн тал түймрийн аюулгүй байдлыг хангуулах" нэгдсэн арга хэмжээ	Хамтран ажиллах байгууллага	■	■	■	■	■							
2	Өвөлжилт, хаваржилт хундрах болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ		■	■	■	■	■					■	■	■
3	Шар усны үеэрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ				■	■	■							
4	Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ							■	■	■				
5	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таныулах өдөрлөг				■									
6	Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөрлөг												■	
7	Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөг				■									

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД
С. Сэгвэлтүвшин
2020 оны 12 дугаар сарын 14 өдөр

**ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ТАНИУЛАХ ӨДӨРЛӨГИЙН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

"Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд иргэд, олон нийтийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоол "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", 340 дүгээр тогтоол "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам", 2016 оны 282 дугаар тогтоол "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай", 2017 оны 67 дугаар "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай" тогтоолууд тус тус эрх зүйн үндэс болно.

2.2. Өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулахад дээрх хууль тогтоомж, энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3. Энэхүү өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд аж ахуй нэгж, байгууллага, ард иргэдэд болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

2.4. Аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдэд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, болзошгүй аюулын үед өөрийгөө болон бусдыгаа авран хамгаалах дадлага сургуулийн талаар мэдээ, мэдээлэл, иргэдэд зориулсан зөвлөмж, сурталчилгаа, явуулах, гарын авлага, видео шторкыг албаны www.nema.gov.mn цахим хуудаснаас татаж авна.

Гурав. Хугацаа, хамрах хүрээ

3.1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолын хүрээнд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр (2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр), 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын хүрээнд хийгдэх нэгдсэн дадлага сургууль (2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр)-ийг төв, орон нутгийн хэмжээнд тус тус зохион байгуулна.

3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах алба, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, байгууллагууд, их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ард иргэд, айл өрхөд чиглэгдэнэ.

Дөрөв. Зохион байгуулагдах үйл ажиллагаа

4.1. Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг иргэд, олон нийтэд таниулах, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургууль зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулах.

сэдвээр сургууль, цэцэрлэгийн багш, сурагчдад хичээл зааж, "Анхаар" аппликейшн, хүн нэг бүрийн үүргэвчинд байх зүйлсийг хэрхэн ашиглах талаар сургууль, цэцэрлэгийн багш, сурагчдаар дадлага хийлгэх.

4.2. "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр" болон "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах" нэгдсэн дадлага сургуулийн талаар холбогдох байгууллагуудын мэргэжлийн албан тушаалтнуудыг оролцуулсан шууд ярилцлагыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд хүргэх.

4.3. Гамшгаас хамгаалах Улсын албадад болон төв, орон нутгийн албадад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.

4.4. Төв, орон нутгийн зарлан мэдээлэл дамжуулах хүч хэрэгслийг нэмэгдүүлэх, зарлан мэдээлэл дамжуулах техник хэрэгслийн бэлэн байдалд үзлэг шалгалт явуулж, дүнг танилцуулах.

4.5. Үүрэн телефоны оператор компаниудтай хамтарч гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах сургалт, дадлага зохион байгуулах талаар олон нийтэд мэдээлэл хүргэх.

4.6. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын 2011 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 08 дугаар захирамж "Хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйлс"-ийн жагсаалтын дагуу иргэн бүрээр бэлтгүүлэх ажлыг зохион байгуулах.

4.7. "Цугларах" талбайг тэмдэгжүүлэх, тохижуулах, орон нутгийн хэмжээнд байгаа цугларах талбайн бүртгэл судалгааг гарган, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор албажуулах ажлыг зохион байгуулах.

4.8. Гамшгаас хамгаалах алба, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагууд, их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг гамшгаас хамгаалах төлөвлөгөөндөө тодотгол хийж, байгууллагын ойролцоох "Цугларах" талбайг тодотгох.

4.9. Зохион байгуулсан арга хэмжээний дүн, мэдээг 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн дотор, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтний ariunaanema@gmail.com цахим хаягаар гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудсын хамт ирүүлнэ.

Тав. Өдөрлөгийн арга хэмжээний үр дүн, шаардагдах зардал

5.1. Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

5.2. Улсын хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн талаар дүнг Гамшгаас урьдчилан сэргийлэх газар нэгтгэн дүгнэж, Монгол Улсын Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын даргад 2021 оны 03 дугаар сарын 31-ний дотор танилцуулна.

5.3. Өдөрлөгийн арга хэмжээг явуулахад шаардлагатай зардлыг тухайн шатны Засаг даргын тамгын газрын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал, Онцгой байдлын газар, хэлтэс тус тус санхүүжүүлнэ.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР